



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/74

Өвт

Зөвлөл шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн банкны итгэлцлийн сан болох Японы нийгмийн хөгжлийн сангийн санхүүжилтээр Японы хүүхдийг Ивээх сангийн хэрэгжүүлэх “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершилийн боловсрол олгох” төслийг удирдан чиглүүлэх үүрэг бүхий “Төслийн сумын зөвлөл”-ийг шинэчлэн дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Н.Орхонтуул (Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: Н.Нямхүү (Сургалтын менежер)

Гишүүд: Б.Ууганчимэг (Ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан тушаалыг түр орлон гүйцэтгэгч)

Ж.Нямтогтох (1 дүгээр багийн Засаг дарга)

Г.Доржханд (Хууль, эрх зүйн мэргэжилтэн)

Г.Цэрэндулам (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Б.Бямбадорж (ЕБС-ийн Нийгмийн ажилтан)

Б.Орбиш (Нийгмийн ажилтан)

Н.Түвшин (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

Г.Бямбагарав (сумын Хүүхдийн элч)

Г.Дуламдорж (Насан туршийн боловсролын арга зүйч)

2. Төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, явц үр дүнг жилийн эцэст сумын Засаг даргын зөвлөлийн хуралд мэдээлж ажиллахыг “Төслийн сумын зөвлөл”-ийн дарга (Н.Орхонтуул)-д үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 13-ний өдрийн “Зөвлөл байгуулах тухай” А/88 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

627205133

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/